



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай


Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "ОИГ" хүнсний дэлгүүрт тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

Хоёр. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж, үйл ажиллагаа явуулж буй объектынхоо эргэн тойрны 50 метр газрын цэвэрлэгээ болон хотын тохижилт, соёлжилтод онцгой анхааран, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллахыг иргэн (Д.Мөнхчулуун)-д үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Э.Цэрэннадмид), Цагдаагийн хэсгийн байцаагч (М.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ